

ГОЛ, УСНЫ САВ ГАЗАР БОЛОН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРУУДАД
ХЭРЭГЖИЖ БАЙГАА ХУУЛЬ, ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Булган аймаг дахь Төрийн аудитын газар

2018 он

БАТЛАВ.
БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Д.АНХБАЯР

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2018.04.30

Булган

1. Аудитын нэр:

Гол усны сав газар болон тусгай хамгаалалттай газруудад хэрэгжиж байгаа хууль, журмын хэрэгжилтийн үр дүн.

2. Аудитын код:

БУА-2018-02-НА

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Булган аймаг дахь Төрийн Аудитын газрын 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

4. Аудитын зорилт:

Гол усны сав газар болон тусгай хамгаалалттай газруудад хэрэгжиж байгаа хууль, журмын хэрэгжилтийн үр дүнд нийцлийн аудит хийж дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, олон нийтэд мэдээллэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

5. Аудитын хамрах хүрээ:

Булган аймгийн Зэд хантай бүтээлийн нурууны ДЦГ-ын хамгаалалтын захиргаа, Хөгнө тарна байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Хануй голын сав газрын захиргааны 2017 оны санхүүгийн үйл ажиллагаа, түүнтэй холбогдох судалгаа, нотлох баримт, бусад тусгай сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн гүйцэтгэл тус тус хамрагдана.

6. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100-100, 4000, 4100 дугаар стандартууд болон, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, судалгаа тодруулга авах, хэрэгжүүлэгч байгууллагын тайлан, баримт, материалд тулгуурлан баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх, зарим арга хэмжээнээс түүвэрчлэн шалгах зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр,

горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

7. Аудитад ашиглагдах хууль, тогтомж, шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрхийн акт, холбогдох бичиг баримтыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглана. Үүнд:

- + Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- + Төрийн аудитын тухай хууль,
- + Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- + Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
- + Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль
- + Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- + Усны тухай хууль
- + Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- + “Ус үндэсний хөтөлбөр”
- + Холбогдох бусад хууль, эрх зүйн акт, тушаал, шийдвэр

8. Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Намчинсүрэн, гэрээт ажилтан З.Ганбаатар, Х.Баттулга нар хөтөлбөрт заасан хуваарийн дагуу 2017 оны 05 дугаар сарын 01-нээс 06 дугаар сарын 30-ны хооронд ажлын 44 хоногт хийж гүйцэтгэнэ.

9. Эрсдлийн үнэлгээ:

Аудитын төлөвлөлтийн үе шатны явцад судалсан баримт материал, урьдчилсан дүн шинжилгээ, судалгаанд үндэслэн ерөнхий эрсдлийг “Дунд” гэж үзлээ.

10. Аудитын тайлан:

Аудитын тайлан нь энгийн, тодорхой, хоорондийн уялдаа холбоотой байх бөгөөд ерөнхий зүйл, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, байгууллагын удирдах албан тушаалтаны санал болон хавсралт судалгаа тооцоо, тайлбаруудаас бүрдэнэ.

Аудитын тайлангийн төслийг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулж, санал авч аудитын удирдагчид танилцуулан баталгаажуулна.

11. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц:

- А. Боловсон хүчин: 3 хүн 132 хүн / өдөр
- Б. Аудитын нийт өртөг: 7402.5 мянган төгрөг
- В. Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, зургийн аппарат, сканнер болон бусад техник хэрэгсэл
- Д. Дотоод томилолтын зардал: 216.0 мянган төгрөг

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ

ХЯНАЖ ЗӨВШӨӨРСӨН:
БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР

Г.НАМЧИНСҮРЭН

